

ӨРХИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН 20 ... ОНЫ СУДАЛГАА

1.Хаягийн хэсэг

	КОД	
Дүүргийн нэр:		
Хорооны дугаар:		

1. Хорооны Засаг дарга нь жил бүрийн 12-р сарын 20-ны дотор бүртгэлийг цахим дүүргийн ЗДТГ-т хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хянаж, нэгтгэн нь 12-р сарын 25-ны дотор УБ хотын ЗАА цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.Мэдээний хэсэг

Ариун цэврийн байгууламжийн төрөл	МД	Өрх	
		Тоо	Хүний тоо
А	Б	1	2
Ариун цэврийн шаардлага хангасан байгууламжтай $мөр\ 1=(мөр2+мөр3)$	1		
Төвлөрсөн системд холбогдсон	2		
Бие даасан системтэй $мөр\ 3=(мөр\ 4:7)$	3		
Битүү тунгаагууртай	4		
Бохир усны соруулдаг цооногтой	5		
Агааржуулагчтай нүхэн жорлонтой	6		
Био жорлонтой	7		
Ариун цэврийн шаардлага хангаагүй байгууламжтай $мөр\ 8=(мөр\ 9:11)$	8		
Энгийн нүхэн жорлонтой	9		
Нийтийн нүхэн жорлонтой	10		
Задгай	11		
Бохир усны цооногтой	12		
Нийт $мөр\ 13=(мөр1+мөр8)$	13		

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Өрхийн ариун цэврийн байгууламжийн 20... оны судалгааны маягт (ЭАБ-10а) - ыг нөхөх заавар

Судалгааг гэр хороололтой хорооны Засаг дарга гаргана.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ



Байршил: Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө.

Хорооны дугаарыг “Хүн ам”-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон www.ubstat.mn цахим хуудсаас харах боломжтой.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Ариун цэврийн байгууламжийг (АЦБ) шаардлага хангасан ба шаардлага хангаагүй гэж ангилна. Шаардлага хангасан, хангаагүй ариун цэврийн байгууламж нь дараах төрөлтэй байна.

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламж нь төвлөрсөн бохир усны системд холбогдсон болон бие даасан системд холбогдсон гэсэн 2 төрлөөс бүрдэнэ. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай өрхийн тоог (багана 1), тухайн өрхөд амьдардаг хүн амын тоог (багана 2)-д нөхнө.

1 дүгээр мөрөнд: Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай өрх, хүний тоог нөхнө. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид төвлөрсөн бохир усны системд холбогдсон болон бие даасан системд холбогдсон байгууламжийг хамруулна. 1 дүгээр мөрийн дүн нь 2, 3 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна

2 дугаар мөрөнд: Төвлөрсөн системд холбогдсон ариун цэврийн байгууламжтай өрх, хүний тоог нөхнө. Төвлөрсөн систем нь хэрэглээнээс гарсан бохир усыг гадагшлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж юм.

3 дугаар мөрөнд: Бие даасан ариун цэврийн системд холбогдсон (Ариутгах татуургад холбогдсон) өрх, хүний тоог нөхнө. “Ариутгах татуурга” гэж хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж, бохир усны цооногийг хэлнэ. Бие даасан системд өрх, хүний хэрэгцээг хангах зорилгоор суурилуулсан орон нутгийн усан хангамж хариуцсан байгууллагаас хамааралгүйгээр бохир ус зайлуулах бага хэмжээний системийг оруулна. Бие даасан системд битүү тунгаагуур, соруулдаг бохир усны цооног, агааржуулагчтай нүхэн жорлон, био жорлонг хамруулна. 3 дугаар мөрийн дүн нь 4, 5, 6, 7 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

4 дүгээр мөрөнд: Битүү тунгаагуур бүхий бие даасан ариун цэврийн системд холбогдсон өрх, хүний тоог нөхнө. Битүү тунгаагуур нь бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуур. Тунасан лагийг үе үе юүлж цэвэрлэнэ. (Орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан стандартын дагуу хийгдсэн, шаардлага хангасан АЦБ).

5 дугаар мөрөнд: Соруулдаг бохир усны цооногтой бие даасан ариун цэврийн системд холбогдсон өрх, хүний тоог нөхнө. Соруулдаг бохир усны цооног нь бохир усны цооногт холбогдсон АЦБ бөгөөд хуримтлагдсан бохирыг зөөж халдваргүйжүүлэн цэвэрлэдэг үйлчилгээ бүхий байгууламж юм.

6 дугаар мөрөнд: Агааржуулагчтай нүхэн жорлонгийн бие даасан ариун цэврийн системийг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Агааржуулагчтай нүхэн жорлон нь бохир агаарыг өөрийн урсгалаар нь гадагш зайлуулах дээрээс гарсан хоолой бүхий нүхэн жорлон юм. Салхивчийн хоолойн доод төгсгөл нь гишгүүрээс доош байрлана. (Орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан стандартын дагуу хийгдсэн шаардлага хангасан АЦБ).

7 дугаар мөрөнд: Био жорлонгийн бие даасан ариун цэврийн системийг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Био жорлон нь нүүрстөрөгчөөр баялаг материал (Хүнсний ногоо хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй бордоо хийх хуурай жорлон юм (Нийтийн биш, агааржуулалттай, бохирыг зориулалтын бодисоор ариутгадаг эсвэл газарт шингээж цэвэршүүлдэг АЦБ).

8 дугаар мөрөнд: Шаардлага хангаагүй АЦБ-г ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж нь цооног, задгай гэсэн хэсгээс бүрдэнэ. Цооног нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй, машинаар соруулж зөөдөггүй, бохир нь газар шингэх цооногт холбогдсон ариун цэврийн байгууламж юм. Үүнд энгийн нүхэн жорлон, нийтийн нүхэн жорлон, бохир усны цооногийг хамруулна.

9 дүгээр мөрөнд: Энгийн нүхэн жорлонг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Энгийн нүхэн жорлон нь хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадсыг цуглуулж, хуримтлуулах замаар давтан ба нэг удаа ашиглах, гадаргын ургацаас хамгаалсан хаяавч бүхий байгууламж юм. (Гэр хороололд элбэг тохиолдох агааржуулалтгүй, бохируу хөрсөнд шингээдэг жорлон).

10 дугаар мөрөнд: Нийтийн нүхэн жорлонг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Нийтийн нүхэн жорлон нь бохируу газар шингээдэг, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, олон нийтийн зориулалттай, гадаа байрлах бие засах газар юм.

11 дугаар мөрөнд: Бохирыг задгай газар ашиглаж хөрсөнд булах зэргийг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Задгай газар, бут сөөг, ил задгай газар ба жалга, хонхорыг ашиглаж хөрсөөр булах зэргээр (Уутанд болон хогийн саванд хийх, ус зайлуулах сувагт хаях) шууд бохирыг зайлуулах нөхцөл (Эзэнгүй, зориулалтын бус ил задгай бие засах цэг)-ийг ойлгоно. (Эзэнгүй, зориулалтын бус ил задгай бие засах цэг).

12 дугаар мөрөнд: Бохир усны цооногыг ашиглаж байгаа өрх, хүний тоог нөхнө. Бохир усны цооног нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй, машинаар соруулж зөөдөггүй, бохир нь газар шингэх цооногт холбогдсон АЦБ юм.